




Төсөл

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ИВЭЭЛ ДОР ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ЗҮҮН БҮСИЙН АНГЛИ ХЭЛНИЙ ҮГ ҮСЭГЛЭЛИЙН ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Англи хэл эхлэн суралцаж буй сурагчдын үгийн баялагийг нэмэгдүүлэх, үгийг нүдлэн тогтоох, зөв дуудаж сурах, англи хэл сурах сонирхлыг төрүүлэх, Пийрсон хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, Америкийн үндэсний үсэглэлийн тэмцээнийг орон нутгийн сурагчдад танин мэдүүлэхэд энэхүү тэмцээний зорилго оршино.

Хоёр. Зохион байгуулагч:

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, БОЛОВСРОЛЫН ГАЗАР, LANGUAGE LEARNING CENTER ГАДААД ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ТӨВ

Гурав. Хугацаа

2025 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр Хэнтий аймгийн Чингис хотод зохион байгуулагдана.

Дөрөв. Хамрах хүрээ

Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн ЕБС-ийн 5 дугаар анги, 6 дугаар анги, 7 дугаар анги гэсэн 3 төрөлд зохион байгуулагдана.

Тав.Зохион байгуулалт: Үг үсэглэлийн тэмцээнийг Америкийн үндэсний үсэглэлийн тэмцээний дүрмээр явуулах бөгөөд аймгууд төрөл тус бүрт шилдэг 7 оролцогч буюу нийт 21 оролцогчийг оролцуулна.

Үгсээс хөтлөгч 3 удаа үгийг хэлж өгнө. Хэрэв оролцогч үгийн утгыг ойлгож сонсоогүй тохиолдолд тайлбарлуулах хүсэлтийг 1 удаа тавина. Үгийг 1 удаа алдсан тохиолдолд тэмцээнээс хасагдана.

Тэмцээнд ашиглагдах үгс: 5 дугаар анги Wider World Starter, 6-р анги Wider World 1, 7 дугаар анги Wider World 2 сурах бичгийн Unit 1-6 сэдвийн хүрээний үгс

Зургаа. Шагнал: Төрөл тус бүрээс шилдэг 3 оролцогчийг шалгаруулж шагнаж урамшуулна.

- 1 дүгээр байр нэг: Өргөмжлөл, Алтан медаль, дурсгалын зүйл
- 2 дугаар байр нэг: Өргөмжлөл, Мөнгөн медаль, дурсгалын зүйл
- 3 дугаар байр нэг: Өргөмжлөл, Хүрэл медаль, дурсгалын зүйл

Долоо. Бусад: Аймаг бүрийн 21 оролцогчдыг 1-2 багш хариуцан ирэх ба оролцогчид ирж очих унааны зардлыг өөрсдөө хариуцна. Оролцогчид ирэхдээ аян хөнгөл, цагаан хэрэглэл зэрэг ариун цэрийн эд зүйлсийг авчирна.

Удирдамж боловсруулсан: БШУГ-ын мэргэжилтэн Б.Эрдэнэчимэг